


БАТЛАВ:
БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчин,
байгалийн нөөцийн удирдлагын газрын

Дарга П.ЦОГТСАЙХАН

ЗӨВШӨӨРСӨН:
“ЦЭГЭЭН-ҮҮДЭН” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



С.ЦЭРЭНДОНДОВ

**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ТАЛ БУЛАГ 2” НЭРТЭЙ НҮҮРСНИЙ ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХЯНАСАН:

БОУАӨЯ-ны ХБОБНУГ-ын ахлах мэргэжилтэн: Б.САРАН

БОЛОВСРУУЛСАН:

“Цэгээн-Үүдэн” ХХК-ийн Ашиглалтын инженер : Э.ЭНХ-ОЧИР

“Цэгээн-Үүдэн” ХХК-ийн Маркшейдер инженер: Ш.ШИНЭБААТАР

2024 он.

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

1. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл
Төслийн дугаар: 2023/ӨМ-34

Төслийн нэр: Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Талбулаг-2 нүүрсний ордыг ашиглах төсөл

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл	
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Цэгээн-Үүдэн” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011108112	
3	Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар	2831686	
4	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-012466	
5	Уурхайн нэр		Талбулаг-2
6	Ордын нэр		Талбулаг-2
7	Уурхайн байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Сүхбаатар аймаг
8		Сум/Дүүрэг	Сүхбаатар сум
9	Уурхайг ашиглаж эхэлсэн огноо	2014 он	
10	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
11		Сум/Дүүрэг	Хан-Уул дүүрэг
12		Баг/Хороо	2-р хороо
13		Гудамж/Байр	Шаравын гудамж, өөрийн байранд
14		Шуудангийн хайрцаг	-
15		Утас	91062222
16		Факс	
17		Гар утас	99111569
18		Электрон шуудан	sanjaatserendondov@mail.com
19		Вэб хуудас	-
20	Захирлын хаяг	Нэр	С.Цэрэндондов
21		Утас	
22		Гар утас	99111569
23		Электрон шуудан	sanjaa.tserendondov@mail.com
24	ТЭЗҮ батлуулсан огноо	2023 оны 01 сарын 27	
25	Ашиглах хугацаа (ТЭЗҮ-ээр)	5 жил (11 жил)	



1.2 Төслийн байршил

Талбулаг-2 нүүрсний уурхай нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт Улаанбаатар хотоос 520 км, Баруун-Урт хотоос 34 км, Сүхбаатар сумын төвөөс 84 км, Мөнххаан сумаас 60 км зайд оршино.

Зураг 1. Төсөл хэрэгжих газрын байршил



“Цэгээн-Үүдэн” ХХК нь Сүхбаатар сумын нутагт орших Талбулаг нэртэй газарт орших 509.5 га талбайд MV-012466 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгүүдийн солбицлууд

№	Координат	
	Уртраг	Өргөрөг
1	113° 03' 02.27"	46° 55' 01.75"
2	113° 03' 02.28"	46° 55' 51.76"
3	113° 04' 02.28"	46° 55' 51.76"
4	113° 04' 02.28"	46° 56' 31.76"
5	113° 02' 02.27"	46° 56' 31.76"
6	113° 02' 02.27"	46° 55' 01.75"

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Цаг уур, уур амьсгал

Тус орд орчмын нутаг дэвсгэр нь эх газрын эрс тэс уур амьсгалтай боловч үнэмлэхүй өндрийн хувьд нутгийн ихэнхийг нам дор, талархаг газар эзэлдэг учраас ерөнхийдөө дулаан уур амьсгалтай, хур чийг багатай, хуурайдуу уур амьсгалтай бүсэд багтана. Уур амьсгалд өвлийн цагт эсрэг циклон, зуны улиралд баруун зүгээс орж ирдэг циклон ихээхэн нөлөөлнө. Хамгийн бага агаарын температур дунджаар 1-р сард -21.6°C , хамгийн их агаарын температур 7-р сард $+21.5^{\circ}\text{C}$. Хоногийн дундаж агаарын температур намар орой 0°C -аас доош доош бууж хүйтрэх бөгөөд хавар нилээд эрт 0°C -аас дээш дулаарч эхэлдэг учир тус уурхай орчмын жилийн хүйтэн улирал 200-203 хоног байдаг. Хөрснөөс уурших чийгийн нөөц бага учраас дулааны улирлын жилийн дундаж харьцангуй чийгшил 30-60 хувь хүрнэ. 30%-аас бага чийгтэй хугацаа 51-62 өдөр байна. Жилдээ дунджаар 200-300 мм тунадас унадаг ба түүний ихэнх буюу 60-80 % нь зундаа 7, 8-р сард орно. Өвөлдөө хур тундсаар бага, жилийн дунджийн 1.5-3.0 % нь ордог ба цасан бүрхүүл удаан тогтохгүй ууршилын (сублимаци) улмаас үгүй болно. Тус бүс нутаг нь нийтдээ салхи ихтэй. Жилийн дундаж салхины хурд 4.5м/сек байдаг. Салхины хурд 20-40 м/сек хүрэх явдал цөөнгүй тохиолдоно.

2.2 Бүс нутгийн үйлдвэржилт, дэд бүтэц

Сүхбаатар аймаг нь 82.9 мян.км² нутаг дэвсгэртэй. Засаг захиргааны нэгжийн хувьд 13 сум, 67 багтай. Сүхбаатар аймаг нь хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалыг сааруулж, хүн амын өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, орон нутагтаа ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэх, ажилгүйдлийн түвшинг бууруулах, цаашид аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг боловсруулан ядуурлыг эрс бууруулах зорилт тавин ажиллаж байна. Сүхбаатар аймгийн аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр:

- Эрдэс түүхий эдийн нөөцийг ашиглах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх;
- Шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Эрчим хүч, авто-зам, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Аймгийн төвд Технологи дамжуулах төв байгуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Хилийн гарц, боомтуудын үйл ажиллагааг улам сайжруулж, дотоодын хуримтлалыг эрс нэмэгдүүлэх;

“Цэгээн-Үүдэн” ХХК-ийн “Талбулаг-2” нүүрсний уурхай нь Сүхбаатар аймаг болон Дорнод бүсийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх, экспортын бүтээгдэхүүн гаргах боломжтой. Мөн түүнчлэн уурхай байгуулагдсанаар шууд болон шууд бус ажлын байр нэмэгдэх болно.

Тус аймагт зам харилцаа эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд 2014 онд Чингис хот-Баруун-Уртын авто зам ашиглалтанд орсон. Цаашид хэвтээ чиглэлийн төмөр зам, Баруун-Урт-Бичигт чиглэлийн төмөр зам болон авто-замд холбогдсоноор ОХУ болон БНХАУ-тай харилцах таатай нөхцөл бүрдэхийн хамт бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Сүхбаатар аймаг нь харилцаа холбоо, мэдээллийн өргөн сүлжээнд хамрагдсан.

Баруун-Урт хот нь ДБЭХС-тэй 110 кВ-ын өндөр хүчдлийн шугамаар холбогдсон бөгөөд тус уурхай нь Баруун-Уртаас Талбулагийн 10 кВ-ын шугамаар холбогдсон тул уул уурхайн олборлолт, үйлдвэрлэл явуулах бүрэн боломжтой юм.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Талбулаг-2 нүүрсний ордыг ашиглах төсөл нь “Цэгээн-Үүдэн” ХХК-ийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, гадаад худалдааг хөгжүүлэх, иргэдийг ажлын байраар хангах зэрэг чухал ач холбогдолтой боловч төсөл хэрэгжих шатанд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, уурхайн ашиглалтын нөлөөгөөр эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх, ажиллагсдын болон оршин суугчдын эрүүл ахуйг хамгаалах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

3.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах

Агаарын чанар

Ухаж ачих, нүүрс бутлах, ангилан ялгах ажил, уулын цулын тээвэрлэлтээс тархах тоос, шороо уурхайн агаар орчныг бохирдуулах гол эх үүсвэр болно.

Агаар бохирдуулагч хорт хийн эх үүсвэр нь экскаватор, автосамосвал, бульдозер, дугуйт ачигч, дизель станц зэрэг дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тоног төхөөрөмжүүдийн яндангаас гарах утаа юм. Мөн уулын цулыг сийрэгжүүлэх өрөмдлөг, тэсэглээний ажлын үед ялгарах хорт хий, нүүрсний өөрөө шаталтаас гарах хорт утаа агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Ухаж ачих ажил: Экскаватор болон дугуйт ачигчаар хөрс, нүүрсний мөргөцгийг ухаж ачих үед ажлын талбай орчимд их хэмжээний тоосжилт үүсэхээс гадна уурхайн агаар орчныг бохирдуулдаг. Иймд мөргөцгийг услах арга хэмжээ авна. Мөн зам талбайг байнга тэгшилж бульдозер болон автогрейдерээр сул шороог хусч зайлуулна.

Тээвэрлэлт: Хөрсний чулуулаг болон нүүрс тээвэрлэх үед уурхайн агаар орчинд маш их тоос тархах тул авто замыг байнга услах, сул шороо, чулууг хусч зайлуулах, замын арчилгааг сайтар хийх шаардлагатай. Уурхайн үндсэн амуудаар гарах замууд нь сайжруулсан хучилттай байвал зохино. Тоос шороог багасгахад зарим уусмалыг ашиглахаас гадна сүүлийн үеийн тоосжилт дарах шинэ, дэвшилтэт технологиудыг сонгон ашиглаж болно.

Тээвэрлэлтийн үед уурхайд тархах тоос нь тээврийн хэрэгслийн явах хурдаас хамааралтай байдаг тул хурдны хязгаарлалт хийж үйл ажиллагаанд мөрдүүлнэ.

Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн хөдөлгүүрээс гарах хорт хийг хүлцэх хэмжээнд байлгахад техникийн бүрэн бүтэн байдал чухал байдаг. Иймд техник, тоног төхөөрөмжийг тогтмол үзлэг оношлогоонд оруулах, засвар үйлчилгээг байнга хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлнэ.

Нүүрсний өөрөө шаталт: Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх, өгөршлийн бүсэд халалт үүссэн үед галын цэгийг даруй дарж унтраана.

Нүүрсний тоос болон метан хий: Нүүрсний давхаргын далд малталт болон нүүрс дамжуулах, боловсруулах битүү барилга байгууламжид нүүрсний тоос, метан хий хуримтлагдаж тэсрэх аюултай тул тухайн хэсэгт байнгын агааржуулалт хийх бөгөөд ил гал болон оч гаргахыг хатуу хориглоно.

Уурхайн агааржуулалт: Ил уурхайн орон зайд агаарын урсгалын олон янзын зүй тогтол ажиглагдах бөгөөд байгалийн хүчний энэ хөдөлгөөнийг ашиглан ил уурхайд агааржуулалт хийх хэд хэдэн схем байна. Уурхайн байгалийн агаарын урсгал нь салхины хүчээр болон дулааны үйлчлэлээр явагдаж байдаг. Уурхайн гүнд салхины урсгалын хүч үйлчлэхгүй нөхцөлд уурхайн ёроол дахь агаар тогтонгиших нөхцөл үүсэх бөгөөд уурхайн ёроолын гадаргуу халсан нөхцөлд ёроолын агаар халж улмаар хүйтэн агаараар сэлбэгдэж хөдөлгөөнд орон уурхайг агааржуулна. Энэхүү үзэгдлийг шулуун цэгийн конвектив схем гэж нэрлэдэг. Салхины хангалттай урсгал,

түүний энергийн тусламжтайгаар ил уурхай сайн агаарждаг бөгөөд ил уурхайн орон зайнаас бохирдсон агаарыг сэлгэх нөхцлийг бүрдүүлнэ.

Талбулаг-2 уурхай нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн хөндийд суналын дагуу байршилтай тул байгалийн урсгалаар бохирдсон агаарыг сэлгэж уурхайг агааржуулах боломжтой юм.

Экскаватор, бульдозер, автосамосвал зэрэг уулын ажлын бүх тоног, төхөөрөмжүүд нь бүгд агаарын температур тохируулагч буюу кондиционертэй байх шаардлагатай.

3.2 Хөрсөн бүрхэвч

Шинээр олборлолт, ашиглалт (гадаад болон шимт хөрсний овоолгын суурь, барилга байгууламжийн суурийн талбай, авто зам г.м)-д өртөх газруудын өнгөн хөрсийг хуулахдаа үржил шимт хөрс болон түүний доод үеийн шимэрхэг хөрсийг тухайн хөрсүүдийн онцлогоос хамааруулан 10-25 см хүртэл зузаантай хуулна. Хуулсан хөрсөө тусад нь овоолох ба нөхөн сэргээлтийн ажилд ашиглахад нөөцлөн хадгална. Эс тэгвээс эвдэрч доройтсон газруудад биологийн нөхөн сэргээлтэд шаардлагатай шимт хөрсний нөөцгүй болно.

Уул уурхайн олборлох үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрч доройтсон, ялангуяа хурдас чулуулгийн овоолгуудын огцом налуу хажууг сайтар хэлбэршүүлэн засч техникийн нөхөн сэргээлтийг чанартай хийсний дараа шимт хөрсөөр хучина. Үүний дараа биологийн нөхөн сэргээлтийн ажлаар олон наст өвслөг болон буурцагт ургамал тариалж талбайг хөрсжүүлж, ургамлан нөмрөгтэй болгох ажлууд хийгдэнэ.

Олон салаа зам гаргахгүй байхаас гадна ашиглалтанд өртөхгүй талбайг эвдрэлд оруулахгүй байхад ажлаа чиглүүлэн удирдана.

Нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ “Уул уурхайн улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” болон бусад холбогдох журам, заавар, стандарт зэргийг мөрдөнө.

Мөн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг шимт хөрсөөр хучихын өмнө “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008” стандартын дагуу бохирдуулагч бодис, элементүүдийн агууламжийг тодорхойлуулж холбогдох арга хэмжээг авах, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг аль болох богино хугацаанд шимт хөрсөөр хучиж ургамалжуулна. Ингэснээр хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хадгалах нөхцлийг бүрдүүлнэ.

Уурхайн бүс, уулын ажлын талбайд шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүнээр хөрсийг бохирдуулахгүй байх, сэргийлэх үүднээс н хадгалалт, түгээлтэд онцгой анхаарч, түүнийг асгарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Уурхайн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг төрөлжүүлэн ялгаж ангилан зориулалтын цэгт түр хадгалан шил, лааз, хуванцар эдлэл, төмрийн хаягдал зэргийг хоёрдогч түүхий эд авдаг цэгт тушаах, хоол хүнсний хаягдлыг ариун цэвэр, эрүүл ахуйн стандартад нийцүүлэн ариутгал, устгал хийн гэрээт байгууллагаар зайлуулах зэрэг арга хэмжээ авна.

3.3 Газрын гадарга, хэвлий

Уурхайн ашиглалтаас үүдэн бий болсон газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- ☆ Уурхайн хөрсний гадаад овоолгуудыг салхины ноёлох чиглэлд хөндлөн байрлалтайгаар үржил шимт хөрсний овоолгыг 5 м-ээс ихгүй өндөртэй, овоолгын

тогтворжилтын өнцөг 18 градусаас ихгүй, оройн хэсгийг орчны гадаргын төрх байдалтай ойролцоо бөмбөгөрдүү байхаар байгуулах

- ☆ Олборлолтонд өртсөн газрыг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008” стандартын дагуу нөхөн сэргээх
- ☆ Дотоод овоолго хийх боломжтой газруудыг дүүргэж техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх
- ☆ Цаашид ашиглалтын явцад өнгөн үеийн шимт хөрс өртөхөөр бол тусад нь хуулж овоолсны дараа ашиглалт явуулах ба ашиглагдаж буй гадаад овоолгыг хаасны дараа гадаргыг үржил шимт хөрсөөр хучиж нөхөн сэргээх
- ☆ Хөрс болон нүүрсний догол, мөрөгцөг, уурхайн болон овоолгын хажууг уулын ажлын паспортын дагуу авч явах
- ☆ Уурхайн ирмэг болон хөрсний гулсалт, нурал үүссэн газарт анхааруулах тэмдэг тавих, хамгаалалт хийх
- ☆ Үер, уснаас хамгаалах далан шуудуу байгуулах
- ☆ Ан, цав гарсан хэсгийг шаварлаг хөрсөөр дарж агаар нэвтрэхээс хамгаалах
- ☆ Нээсэн ашигт малтмалыг хаягдал, бохирдол багатай иж бүрэн олборлох
- ☆ Хөрсний чулуулаг дахь дагалдах ашигт малтмалыг ашиглах
- ☆ Хөрс хуулалтын коэффициентийг төслийн дагуу жигд байлгах

Уурхайн ашиглагдсан талбайг бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх, үүний тулд Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулах ба хэрэв хортой бодис илэрсэн тохиолдолд хурдас чулуулгийн хорыг саармагжуулах, хоргүйжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4 Гадаргын болон газрын доорх ус

Талбулаг-2 уурхай нь ажиллагсдын унд-ахуйн хэрэгцээт усыг 18 км-т байрлах “Талын гал” ХК-ийн гүний худаг болон ус цэнгэгжүүлэх төхөөрөмжөөр тоноггосон өөрийн худгаас хэрэглэх ба технологийн хэрэгцээнд уурхайн ус шүүрүүлэлтийн усан сангаас ашиглана.

Худгийн усны лабораторийн задлан шинжилгээний дүнг тайлангийн бүрдэлд хавсаргана.

Талбулаг-2 уурхай нь 2024 оноос уурхайн ёроолын ус таталт, шавхан зайлуулалт хийнэ. Шүүрэх усны хэмжээ харьцангуй бага 1.4 л/сек орчим ундаргатай байх бөгөөд шүүрсэн усыг зумпфэнд цуглуулан хуримтлуулж технологийн зориулалтаар тоос дарах замын усалгаанд ашиглана.

Талбулагийн рашаанаас уурхайн карьер 10км зайд байрладаг учир уулын ажлын сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

3.5 Ургамлан нөмрөг

Талбулагийн нүүрсний уурхай орчмын ургамлан нөмрөгийн доройтлыг багасгах, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- ☆ Орд орчмын ургамалжилтын өөрчлөлтийг хянаж байхын тулд тодорхой талбарт мониторингийн цэгийг сонгож байнгын ажиглалт хийж байх, ингэснээр мэдээллийн бааз үүсч, уурхайн нөлөөллийг хянах болон нөхөн сэргээлт хийх судалгааны материал бүрдэнэ.
- ☆ Уурхайн хөрс хуулалтанд өнгөн хэсгийн ургамал өртөж устах, үгүй болох, овоолго, барилга байгууламжийн доор ургамал дарагдах, авто замд эвдэгдэх зэрэг сөрөг

- нөлөөллийг бууруулахын тулд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг цаг алдалгүй чанартай хийнэ.
- ☆ Уурхайн олборлолт явуулж байгаа хэсгийн салхины доод тал болон замын ойролцоох газруудад тоосны хуримтлал үүсч ургамлыг устгах аюултай тул зам талбайг тогтмол усална.
 - ☆ Шатах тослох материал, машин механизмын засварын газар болон уурхайн тосгоны газрыг эмх цэгцтэй зохион байгуулах, орчныг бохирдуулахгүй байх хяналт, зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.
 - ☆ Зам талбай, нөхөн сэргээсэн талбайн арчилгаа, усалгаа тордолтыг байнга хийнэ.
 - ☆ Ургамлын доройтол үүсч бий болох магадлалтай газруудад хил хязгаар тогтоож хамгаална.
 - ☆ Шимт хөрс хуулалт, хадгалалт, хамгаалалтыг стандартын дагуу гүйцэтгэнэ.
 - ☆ Биологийн нөхөн сэргээлтийг байгалийн унаган төрхөд аль болох ойртуулах, мод сөөг, олон настын үр тарих, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918:2008” стандартыг баримтлах
 - ☆ Биологийн нөхөн сэргээлтэнд нутгийн унаган ургамал болон аль болох тухайн нутгийн онцлогт тохирсон ургамлын сорт, үрийг сонгож тариална.
 - ☆ Царгас, хүцэнгэ зэрэг буурцагт ургамал тариалж бусад ургамалд эергээр нөлөөлөх азотоор хангах.

3.6 Амьтны аймаг

- Нүүрс тээвэрлэлт болон уул уурхайд ажиллах машин техникүүдэд дуу чимээний хязгаарлалт хийх ялангуяа амьтны биологийн идэвхит цаг хугацаанд /ороо хөөцөө, нүүдэллэлт, бэлчээрлэлт гэх мэт/ илүү анхаарч ажиллах.
- Дуу чимээний нөлөөгөөр амьтад үргэж дайжин биологийн олон янз байдалд шууд нөлөөлдөг тул уурхай орчимд мод бут тарьж дуу чимээний хязгаарлалт хийх.
- ☆ Нүүрс тээврийн зам дээр амьтан өнгөрөх гарц гаргах, саадгүй нэвтрэх боломжийг бий болгох, тэмдэг тэмдэглэгээ хийх.
 - ☆ Тоосжилтийг бууруулж хуурайшилт ихтэй үед зам талбайг услах.
 - ☆ Уурхайгаас гарах хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт төвлөрүүлэх, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй зөвхөн уурхайн бохирын цооногт зайлуулах, амьтны бэлчээр, усанд ордог булаг шандын ойролцоо газар бохирдуулах, хог хаяхаас зайлсхийж орчны тэнцвэр алдагдахаас сэргийлэх.
- Ил уурхай нь зөвхөн ашиглалт явуулж буй талбайд бус түүний эргэн тойрныг хамарсан радиуст нөлөөлөл үзүүлэх учир уурхай орчмын амьтдын тоо толгой, байршил, шилжилт хөдөлгөөн, тэдгээрийн төрөл зүйл устах болон амьдралынх нь хэвийн орчин нөхцөл алдагдаж буй эсэхэд ажиглалт хийх, хамгаалах арга хэмжээ авах.
- ☆ Уурхайн ойролцоо амьдардаг малчин өрхөөс мал бэлчээрлэлт болон амьтад амьдрах орчин хязгаарлагдаж буй талаар судалгаа авч, сөрөг нөлөөллийг бууруулж ажиллах
 - ☆ Уурхайн ойр орчимд шувууны үүр барих, өндөр хүчдэлийн шонд сэнс байрлуулах зэргээр шувуудыг хамгаалах шаардлагатай арга хэмжээнүүдийг авах.

3.7 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ. Төслийн хугацаанд жил бүрийн 3-р улирлаас эхлэн бүс нутгийн байгаль, цаг агаарын онцлог, хүрээлэн буй орчны унаган төлөв байдалд тухай бүр нийцүүлэн дүйцүүлэн хамгаалах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх.

3.8 Нөхөн сэргээлтийн арга хэмжээ

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажил нь уул-техникийн, инженерийн, хөдөө аж ахуйн болон бусад төрлийн арга хэмжээнээс бүрддэг.

Талбулаг-2 нүүрсний уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд өртөх газрыг бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх шаардлагатай. Иймд төслийн талбайн 95 орчим хувийг бэлчээрийн зориулалтаар, 5 хувьд мод, бут, хүнсний ногоо тарих байдлаар нөхөн сэргээх боломжтой. Эхний ээлжинд уурхайн тосгонд мод тарих, ажилчдын хүнсний хэрэгцээнд төмс, хүнсний ногоо болон төрөл бүрийн ургамлын үрийг туршилтын журмаар тарьж цаашид нөхөн сэргээлтэнд тохирох ургамлыг сонгон тариална.

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл ажил нь техникийн болон биологийн нөхөн сэргээлт гэсэн 2 үндсэн үе шатаар хийгдэнэ.

3.9 Байгаль орчинд үзүүлж болзошгүй эрсдлийн үнэлгээ

Хүснэгт 11. Байгаль орчинд учирч болзошгүй эрсдлийн үнэлгээний матриц

матриц

№	Нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Бага	Дунд	Их	Онцгой их
1	Гал түймэр гарах	Зайлшгүй болох				
		Болох магадлалтай				
		Болзошгүй			+	
		Болох магадлал бага				
		Болохгүй				
2	Шатах тослох материалын хадгалалт	Зайлшгүй болох				
		Болох магадлалтай			+	
		Болзошгүй				
		Болох магадлал бага				
		Болохгүй				
3	Хог хаягдлын зайлуулалт	Зайлшгүй болох			+	
		Болох магадлалтай				
		Болзошгүй				
		Болох магадлал бага				
		Болохгүй				
4	Ашиглалтын технологи зөрчих	Зайлшгүй болох				
		Болох магадлалтай			+	
		Болзошгүй				
		Болох магадлал бага				
		Болохгүй				
5	Тоосжилт	Зайлшгүй болох			+	
		Болох магадлалтай				
		Болзошгүй				

		Болох магадлал бага				
		Болохгүй				
6	Дуу шуугиан	Зайлшгүй болох		+		
		Болох магадлалтай				
		Болзошгүй				
		Магад болохгүй				
		Болохгүй				
		Маш бага эрсдэлтэй				
		Хүлцэж болох эрсдэл				
		Эрсдлийг бууруулж болохуйц				
		Эрсдлийг зайлшгүй бууруулах				

Дээрх хүснэгтээс харахад төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй 6 сөрөг тохиолдол байна. Үүнээс:

- ☆ Их эрсдэлтэй, тохиолдож болзошгүй 1 тохиолдол
- ☆ Их эрсдэлтэй, болох магадлалтай 2 тохиолдол
- ☆ Дунд эрсдэлтэй, тохиолдох зайлшгүй болох магадлал 3 тохиолдол тус тус тохиолдох магадлалтай байна.

Нийт эрсдэл нь тохиолдол магадлал багатай ч хэрэв эрсдэл учирсан тохиолдолд байгаль орчинд үзүүлэх эрсдлийн хэмжээ өндөр байна. Болзошгүй эрсдэл гарсан тохиолдолд бууруулах арга хэмжээг удирдлагын зүгээс цаг алдалгүй яаралтай авах шаардлагатай ба сум, орон нутагт болон мэргэжлийн хяналт, онцгой байдлын албанд мэдэгдэх хэрэгтэй.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, хэрэгжүүлэх үе шат зэргийг нарийвчлан тусгасан эрх зүйн баримт бичиг болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан арга хэмжээнүүдийг шат дараатай төлөвлөж хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт хийгдэх ажил, холбогдох төрийн байгууллага, сум орон нутгийн оролцогч талуудын санал дүгнэлтэнд үндэслэн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г тус тус удирдлага болгон боловсруулсан.

Дараах ажлуудаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг боломжит хамгийн бага хэмжээнд хүргэх зорилт тавьж байна. Үүнд:

1. Байгаль орчны холбогдох хууль, тогтоомжуудыг мөрдөж ажиллах Байгаль орчныг хамгаалах шилдэг аргуудыг үйл ажиллагаандаа бий болгох удирдлагын системийг хэрэгжүүлэх.
2. Бүхий л үйл ажиллагаандаа "багасгах, дахин боловсруулах, дахин ашиглах" зарчмыг хэрэгжүүлэх.



3. Ажиллагсдын байгаль орчноо хамгаалах хариуцлага, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, төслийн талбайд мөрдөгддөг дүрэм журмыг хэрэгжүүлэх хүрээнд шаардлагатай сургалт, мэдээ, мэдээлэл, сургалт зохион байгуулах.
4. Байгаль орчныг хамгаалах өөрсдийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, үйлчлүүлэгч болон ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллах.
5. Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөлт хэрэгжилтийг тогтмол сайжруулах.
6. Ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжийн хүрээнд мөрдөгддөг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.
7. Компанийн дотоод дүрэм, журамд байгаль орчныг хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх заалтуудыг тусган мөрдүүлэх.
8. Нийт ажиллагсад, гэрээт байгууллага, ханган нийлүүлэгчид, сонирхогч талуудад байгаль орчны баримтлах бодлого, зорилгыг таниулах, уурхайд мөрдөх дүрэм, журмуудыг мөрдүүлэх.



5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар:									
1.1	Уурхайн олборлолт болон тээвэрлэлтээс тоосжилт үүсэх.	Ордын дотоод тээвэрлэлтийн замд тоосжилт бууруулах шинэлэг технологи нэвтрүүлэх	Уурхайн ашиглалтын талбай	-	-	-	Уурхайн ашиглалтын зардалд орсон	-	Агаарын тухай хууль, Агаарын чанарын ерөнхий шаардлага MNS 5365:2004
1.2		Зам ашиглалтаас үүссэн туйран, эвдрэлд тогтмол арчилгаа хийх.		Төг	-	-	500.000	Тогтмол	
1.3		Хүнд машин механизмууд, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх		-	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	-	



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.4		Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах		-	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Тухай бүрд	
1.5		Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох агаарын бохирдлын төлбөрийг хуульд заасан хувь хэмжээгээр журмын дагуу тогтмол төлөх		-	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	-	
1.6		Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Удаа	-	2	Орчны шинжилгээний зардалд орсон	Жилд 2 удаа	
Гадаргын ба газрын доорхи усны нөөц									
2.1	Үйл ажиллагааны улмаас газрын гадаргын болон газрын доорхи усны нөөц багасах, бохирдох.	Ус ашигласны төлбөрийг зохих журмын дагуу тооцож орон нутгийн байгууллагад цаг хугацаанд нь төлөх	Ундны ус	-			Үйл ажиллагааны зардалд орсон	Ашиглалтын хугацаанд	Усны тухай хууль, Ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900-2018, Бусад дүрэм журам.
2.2		Уурхайн шүүрч буй усыг зумпфэд хадгалах ба цэвэрлэгдсэн усыг замын тоосжилт дарахад хэрэглэх	Уурхайн талбай	-	-	-	-	-	



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.3		Худгийн ус цэвэршүүлэгийг шинэчлэх	Ажилчдын хотхон	-		1	Үйл ажиллагааны зардалд орсон	Жилд 1 удаа	
2.4		Усны чанарын үзүүлэлтийг хэмжих.		ш	-	2	Орчны шинжилгээний зардалд орсон	Жилд 2 удаа	
Хөрсөн бүрхэвч									
3.1	Шатах тослох материалаар болон ашиглалтын үеийн хөрс бохирдолт	Уурхайн малталтанд өртөх талбайн шимт хөрсийг ангилан хуулж, нар салхины нөлөөгөөр элэгдэхээс хамгаалах	Уурхайн ашиглалтын талбай	м3	-	-	Уурхайн ашиглалтын зардалд орсон	Байнга	Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
3.2		Шимт хөрсийг хуучин овоолгонд нэмж хадгалан нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглах, бүртгэл хөтлөх, тооцоог хянах		м3	-	-	Үйл ажиллагааны зардал	Шимт хөрс хуулах, овоолго хийх, дахин ашиглах үед	
3.3		Уурхайн орчмын дотоод тээвэрлэлтийн замын тэмдэгжүүлэлтийг нэмэх		-	-	-	Үйл ажиллагааны зардал	-	



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3.4		Тээврийн хэрэгслийг олон салаа зам гаргахгүйгээр тогтсон нэг маршрутаар явуулах		-			Үйл ажиллагааны зардал	Тогтмол		
3.5		Хог хаягдлыг зориулалтын ангилан ялгадаг саванд хадгалах гэрээт байгууллагаар хугацаанд нь тээвэрлүүлэх	Ажилчдын хотхон	-		-	250,000	Тухай бүрд	Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга	
3.6		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах	ШТС	-		-	Үйл ажиллагааны зардал	Асгаралт гарсан тухай бүрд.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	
Газрын хэвлий:										
4.1	Газрын зүй зохистой ашиглалтаас үүдсэн газрын эвдрэл ихээр үүсэх	Нүүрсний хаягдал, бохирдолтыг багасгах	Нүүрсний давхарга	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Нүүрс олборлох явцад	Уурхайн хөдөлмөр зохион байгуулалт	
4.2		Газрын хэвлийг зөвхөн зураг төсөл, төлөвлөгөөний дагуу ашиглах	Уурхайн ашиглалтын нийт талбай			-	Үйл ажиллагааны зардал	Ашиглалтын хугацаанд		
4.3		Нөлөөлөлд өртсөн газрын хэвлийг дотоод овоолгоор дүүргэж нөхөн сэргээх	Уурхайн малталанд өртсөн талбайн орон зай	-	-	-	Уурхайн ашиглалтын зардалд орсон	Жил бүр		



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Ургамлан нөмрөг									
5.1		Мод үржүүлгийн талбайд 4 зүйл ургамлын үрээр тарилт үрсэлгээ хийх.	Мод үржүүлгийн талбай	ш	-	50	Үйл ажиллагааны зардал	4-5-р сард	Байгаль орчны тухай хууль
Амьтны аймаг									
6.1	Олборлолтын үйл ажиллагаанаас хамаарч биологийн төрөл зүйл хомсдох, амьдрах таатай орчин буурах.	Олон салаа зам гарч бэлчээр талхлагдахаас сэргийлж шаардлагатай хэсгүүдэд замын тэмдэглэгээ хийх	Уурхай орчмын талбай	-	-		Үйл ажиллагааны зардал	Ашиглалтын хугацаанд	Уурхайн хөдөлмөр зохион байгуулалт
6.2		Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	Уурхайн орчимд	-			Үйл ажиллагааны зардал	Ашиглалтын хугацаанд	Уурхайн хөдөлмөр зохион байгуулалт
6.3		2023-2024 онд нүүрлэсэн зудын улмаас үүссэн мал, бэлчээрийн ан амьтадын сэг зэмийг ачих, тээвэрлэх, булах	Сүхбаатар сумын хэмжээнд	-			Үйл ажиллагааны зардал	3 сард	БОАЖЯ ны ХАМЖИХГҮЙ БОЛ АМЖИХГҮЙ уриалгын хүрээнд
Зардлын нэгдсэн дүн							750,000		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлт ийн зорилт	Нөхөн сэргээлт ийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
6.1	Техникийн нөхөн сэргээлт	Орон нутгийн чанартай олон салаа замыг хааж техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх.	га	0.9	-	588,000.0	8-р сар	Эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал,
6.2		Ажилчдын хотхонд мод суулгац ногоон байгууламжыг нэмэгдүүлэх.	ширхэг	50	11,000	550,000.0	5-р сар	
6.3	Биологийн нөхөн сэргээлт	Мод үржүүлгийн талбай болон шинээр тарилт хийсэн талбайд усалгааны систем хийх.Услах	-	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Тогтмол	Нөхөн сэргээлт хийх журам зааварчилгаа
Зардлын нэгдсэн дүн						1,138,000.0		

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
7.1	Дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгаа	Зэрлэг амьтдын зүйлийн тархалтад ажиглалт мониторинг хийх, үр дүнгээр цаашид авах арга хэмжээг төлөвлөх	Төслийн нөлөөллийн бүс болон дүйцүүлэн хамгаалах газарт	1	1,000,000	1,000,000	2024 оны 1,2-р улирал	2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоол, БО НБНУ-ний тухай хууль,
7.2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх зардал	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг талуудын оролцоотойгоор төлөвлөх, холбогдох байгууллагаар батлуулах	Дүйцүүлэн хамгаалах газрын хэмжээнд	1	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Жил бүр	
7.3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардал	Мэргэжлийн байгууллагатай хамтран биологийн төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээг төлөвлөх	Дүйцүүлэн хамгаалах газрын хэмжээнд	1	500,000	500,000	Жил бүр	
7.4	Нутгийн иргэдийн оролцоотой хамгаалалт, хяналтын менежмент бий болгох	Мэргэжлийн болон орон нутгийн иргэдтэй хамтран амьтдын тооллого, мониторинг судалгааг хийлгэх, хяналтын механизм бий болгох	Нутгийн иргэд болон сонирхогч талууд	1	500,000	500,000	Жил бүр	
7.5		Байгаль орчны сургалтыг нутгийн иргэдийн дунд явуулах		1	500,000	500,000	Жил бүр	
7.6		Биологийн олон янз байдлыг хамгаалах, талаар гарын авлага товхимол хэвлүүлэх		1	300,000	300,000	Жил бүр	
Зардлын нэгдсэн дүн						2,800,000		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
8.1	Уурхайн эдэлбэр газрын нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох нөхцөл байдал үүсээгүй учир ажил төлөвлөөгүй.							
Зардлын нэгдсэн дүн						-		

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
9.1	Археологийн дурсгал	Уурхайн эдэлбэр газарт Археологийн дурсгалт эд зүйлс байхгүй учир ажил төлөвлөөгүй.						
9.2	Палеонтологийн дурсгал	Уурхайн эдэлбэр газарт Палентологийн дурсгалт зүйлс байхгүй учир ажил төлөвлөөгүй.						
Зардлын нэгдсэн дүн					-	-		

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
10.1	Болзошгүй байгалийн гамшиг, халдварт өвчин гал түймэр	Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг ОБГ-р батлуулж мөрдөж ажиллах	Уурхайн бүсэд ажиллаж буй ажиллагсад, үйл ажиллагаа	Тодорхойлох боломжгүй	ХАБЭА-н зардалд тусгагдсан	-	Тухайн жилдээ	Гамшгийн тухай хууль, ХАБЭА-н дүрэм журам, зааварчилгаа
10.2		Цаг агаарын урьдчилсан мэдээг 5 хоног тутамд мэдээллэх	Уурхайн бүсэд явагдах бүх үйл ажиллагааны хэмжээнд	Мэдээллэсэн тоо, аюудлтай үзэгдлийн давтамж	Дотоод зардал	-	Тухайн жилдээ	



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

10.3	Химийн бодисын хордлого	Засварын төв, нүүрс шинжилгээний лабораторид ашиглагддаг химийн бодисуудын ХАЛМ-г боловсруулах	Уурхайн бүсэд явагдах үйл ажиллагааны хүрээнд	Ашиглагдаж байгаа химийн нэгдлийн тоо ХАЛМ	Дотоод зардал	-	Тухайн жилдээ	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Ажлын байрны стандарт MNS 4940
	Нийт					-		



11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
11.1	Ахуйн	Ахуйн хог хаягдлыг түр хуримтлуулах цэгт хадгалж Баруун-Урт хотын нэгдсэн хогийн цэг рүү нийлүүлэх.	Уурхайн талбай	Удаа	40,000	12	480,000	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
11.2		Хог хаягдал тээвэрлэх, булах устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулах	Төслийн бүс	-	-	-	-	3-р сард	
11.3		Хог хаягдлын ангилан ялгах хогийн сав нэмэгдүүлэх, ангилан ялгалтыг сайжруулах.		ш	-	2	100,000	Жилд	
11.4	Үйлдвэрийн	Хаягдал төмөр болон барилгын хог хаягдлыг ангилан ялгаж тусгай талбайд байршуулан дахин ашиглах болон дахин боловсруулах иргэн аж ахуйн нэгжид нийлүүлэх.	Уурхайн талбай	тн	-	-	-	Жилд	



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

11.5		Ахуйн, үйлдвэрийн, аюултай хог хаягдлыг боломжит хэмжээгээр 2-догч түүхий эд авах аж ахуйн нэгжид нийлүүлэх	Төслийн бүс	тн	-	2	-	Жилийн турш
11.6	Аюултай	Техник үйлчилгээнээс гарсан хаягдал тосыг тусгай цэгт хуримтлуулж дахин боловсруулах үйлдвэртэй гэрээ хийх.	Засварын төв	тн	-	10	1,000,000	Жилд 2
11.7		Аюултай хог хаягдалд сар бүр үзлэг шалгалт хийж Бүртгэл хөтлөх.	Уурхайн талбай	-	-	-	-	Сард 1 удаа
Зардлын нэгдсэн дүн							1,580,000	

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
12.1	Агаарын сорьцын шинжилгээ	Төслийн бүс, нөлөөллийн бүс	Жилд	2	-	100,000	Сүхбаатар аймгийн УЦУОШТөв	MNS 00172-5-12:1988, NS4586-98 усны чанарын стандарт
12.2	Худгийн усны шинжилгээ	Уурхайн бүс	Жилд	2	-	100,000		
12.3	Шүүрүүлэлтийн усны шинжилгээ	Ахуйн хэрэгцээний худаг, Гал тогоо, цэвэрлэх байгууламж	Жилд	2	-	50,000		



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

12.4	Хөрсний шинжилгээ	Шүүрлийн ус, худгийн ус, гал тогоо, нөлөөллийн бүсийн уст цэг	Жилд	2	-	100,000		
12.5	Цацраг идэвхит бодисын хяналт шинжилгээ	Засвар, ШТС, Шимт хөрсний овоолго, хогийн цэг, Нөлөөллийн бүс, Гаалийн талбай, Кемп,	Жилд	2	-	150,000		
Зардлын нэгдсэн дүн						500,000		

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
13.1	ТЭЗҮ-ийг баримтлаж ажиллах .	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш			Уурхайн дарга	Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг орших “Талбулаг-2” хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ ийн тодотгол
13.2	БОННУ-ний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш			БО мэргэжилтэн	“Талбулаг-2” хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах БОННУ ийн тодотгол
13.3	Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, тайланг холбогдох газарт хүргүүлэх	Үйл ажиллагааны зардал	12	1	2	Уулын инженер	Ашигт малтмалын тухай хууль



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

13.4	Аваар устгах төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал	5	6	7	ХАБ-ын инженер	-
13.5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал	12	-	-	БО мэргэжилтэн	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам,
13.6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	Үйл ажиллагааны зардал	11	-	-	БО мэргэжилтэн	
13.7	Мэргэжлийн байгууллагаар дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө боловсруулах	Үйл ажиллагааны зардал	-	-	-	БО мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
13.8	Мэргэжлийн байгууллагаар газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх	7,700,000	4-11 сар			БО мэргэжилтэн	Газрын тухай хууль, Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх ажлын түр журам, 2013
13.9	Мэргэжлийн байгууллагаар байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэж, дүгнэлт гаргуулах ажлын зардал	8,800,000	4-11 сар			БО мэргэжилтэн	Байгаль орчны аудит хийх журам, 2013
13.10	Орон нутагтай гэрээ байгуулах	-	4-11 сар			Уурхайн дарга	Дотоод журам
13.11	Тос тосолгооны материалын хаягдлаар хөрс бохирдуулахгүй байх (асгах, гоожуулах г.м)	Үйл ажиллагааны зардал	4-11 сар			БО мэргэжилтэн	Дотоод журам
13.12	Усны хэрэглээнд хяналт тавьж үр ашигтай зарцуулалт бий болгох, усны хэрэглээг багасгах, зам талбай, ногоон байгууламжийг услахад ус шүүрүүлэлтийн ус ашиглах, усыг хэмнэлттэй ашиглах заавар санамж байрлуулах	Үйл ажиллагааны зардал	4-11 сар			БО мэргэжилтэн	Дотоод журам
13.13	Газар ашигласны төлбөр төлөх	Үйл ажиллагааны зардал	4-11 сар			Уурхайн дарга	Газрын төлбөрийн тухай хууль,



Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

13.14	Ажилчдын байгаль орчны мэдлэгийг сайжруулах сургалт зохион байгуулах:	Үйл ажиллагааны зардал	4-11 сар			БО мэргэжилтэн	Дотоод журам
13.15	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулах	Үйл ажиллагааны зардал	4-11 сар			Уурхайн дарга	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам, 2014
13.16	Байгаль орчныг хамгаалах талаар мэдээллийн самбар хийж байршуулах	Үйл ажиллагааны зардал	4-11 сар			БО мэргэжилтэн	Дотоод журам
13.17	Сүхбаатар аймгийн УЦУОША-тай гэрээ байгуулж орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан сорьц, дээжийг авч шинжлүүлж дүгнэлт гаргуулах	Орчны шинжилгээний хөтөлбөрийн зардалд тусгасан	5		11	БО мэргэжилтэн	Агаарын бохирдлын тухай хууль
13.18	Уурхайн ашиглалтын талбайд хаалт, хамгаалалт, тэмдэглэгээ хийж уурхайг хаягжуулах	Үйл ажиллагааны зардал	3	4	5	ХАБ-ын инженер	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
13.19	Уурхайг үерийн уснаас хамгаалах далан шуудуу байгуулах	Үйл ажиллагааны зардал	3	4	5	Уулын инженер	
Нийт		16,500,000					



14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
14.1	Уурхай орчимд амьдардаг малчид болон Талбулаг тосгоны иргэд	Бичгээр болон презентэйшн	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	11 сар	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн кемп
Зардлын нэгдсэн дүн							

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Зардлын дүн /төг/
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	750,000
2	Нөхөн сэргээлт	1,138,000
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	2,800,000
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	-
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,580,000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	16,500,000
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	-
11	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	500,000
Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв		23,268,000

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

“Талбулаг-2 нүүрсний ордыг ашиглах төсөл”-ийг Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 5-р багийн нутаг Талбулаг нэртэй газарт “Талбулаг-2 нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэл”, Уурхай, уулын үйлдвэр ашиглалтанд хүлээн авах улсын комиссын акт зэргийг үндэслэн 2014 оны 10-р сараас эхлэн хэрэгжүүлсэн. “Цэгээн-Үүдэн” ХХК нь тус төслийг хэрэгжүүлснээр Баруун-Уртын 15 мегаваттын чадалтай дулааны станц болон орон нутгийн түлшний хэрэгцээг хангах, цаашид нүүрс экспортлох, ажлын байрыг нэмэгдүүлэх, дэд бүтэц, бүс нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд тодорхой үүрэг хүлээн оролцоно. Төслийн ашиглалтын 2024 онд 9 га талбай уурхайн малталтанд, 9.3 га талбай гадаад овоолго, 1 га талбай шимт хөрсний овоолгын суурийн талбайд өртөнө. “Цэгээн-Үүдэн” ХХК нь 2014 оны 10 сард палеонтологи, археологийн хайгуул, судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд эдгээр судалгааны дүгнэлтээр археологи, палеонтологийн олдвор илрээгүй байна. Талбулаг-2 нүүрсний уурхай нь ЗГ-ын 2012 оны 194-р тогтоолоор батласан Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн зааг, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хил заагтай тус тус давхцалгүй байна. Уурхайн унд ахуй болон технологийн хэрэглээнд “Талын гал” ХК-ийн гүний худаг болон цэнгэгшүүлэх төхөөрөмж тавьсан өөрийн худгаас хэрэглэх ба Талын гал ХК-ийн худаг нь уурхайгаас 18 км-т байрладаг тул уурхайн үйл ажиллагаанаас худгийн усны чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй, нөөц/багасах, хомсдох/-өд бага хэмжээгээр нөлөөлнө. Иймд сөрөг нөлөөллийг бууруулах талаар арга хэмжээ авч ус ашиглах гэрээг сум орон нутагтай жил бүр хийж дүгнүүлэх, усны төлбөрийг зохих газруудад төлж байх хэрэгтэй. Уурхайд 200 хүн ажиллах ба унд ахуйн хэрэглээнд хоногт 1.7 м3, жилд 602.5 м3/жил ус хэрэглэх тооцоо гарсан байна. Үүнээс хэрэглэсэн цэвэр усны 75% нь шингэн хаягдал болно гэж үзвэл жилд 465.37 м3 ахуйн шингэн хаягдал гарна. Талбулаг-2 уурхай нь 2024 оноос эхлэн ус шүүрүүлэлт хийж эхлэх тооцоололтой байгаа ба шүүрсэн усыг зумпфинд хуримтлуулан зам талбай услах, тоос дарах зэрэг технологийн хэрэгцээнд ашиглана. Хатуу ба шингэн хог хаягдлыг ил задгай хаяхгүй бөгөөд хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж тэдгээрийг дарж булах, гэрээт байгууллагаар зайлуулах зэрэг ажлыг гүйцэтгэнэ. Тосгоны айл өрхөөс гарах хаягдлыг энэ төлөвлөгөөнд хамруулна. Уурхайн хаалтыг бэлчээрийн зориулалтаар хөдөө аж ахуйн чиглэлээр хаахаар төлөвлөсөн ба нөхөн сэргээлтийг чанартай гүйцэтгэж уурхайн орон нутагт хүлээлгэн өгөх шаардлагатай. Тус багийн иргэдийн нийтийн хурлаар хуралд оролцогсод 100%-ийн саналаар “Цэгээн-Үүдэн” ХХК-ийн үйл ажиллагааг дэмжиж цаашид хяналт тавьж, байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хамтран ажиллах саналтай байгаагаа илэрхийлсэн байна. Талбулагийн уурхайн 2024 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 23,268 сая төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 0.5 сая төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарч байна. Бүс нутгийн болон улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд ач холбогдолтой тул “Цэгээн-Үүдэн” ХХК нь Монгол улсад мөрдөгдөж буй хууль, журмын хүрээнд үүрэг, хариуцлагаа хүлээж “Талбулаг-2 нүүрсний ордыг ашиглах төсөл”-ийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.